

## 1. ФИЛОСОФИЙН ТҮҮХ

### ШУДАРГА ЁСНЫ ТУХАЙ ПЛАТОНЫ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Доктор Ш.Ганхуяг

**Түлхүүр үг:** Түүх, нийгэм, соёл иргэншил, ёс суртахуун, хууль цааз, Грекийн философи, түүхийн философи, үнэ цэнэ, хөдөлмөр, ашиг

**Товч утга:** Хуулийг мөрдөх нь шударга явдал гэж бид боддог. Гэвч хуулиас ангид, хууль зөрчсөн үйлдлүүд тухайн хүндээ ашиг авчрах нь элбэг болжээ. Хууль зөрчигсдийг бид бүх талаар шүүмжлэн харааж зүхэцгээдэг. Гэтэл тэд “чадаж байхад арга байхгүй” гэж хэв нэг хариулна. Үнэндээ тэдний зөв ажгуу. Энэ талаар бүр манай тооллоос өмнөх үеийн Грекийн нэрт сэтгэгч Платон “Төр улс” зохиолдоо тодорхой тайлбарласан байдаг. Энэ тайлбар яг одоо бидэнд хэрэг болох чухал зүйлийг өгүүлнэ.

Платон бичихдээ: “шударга бус явдалт хүнтэй харьцуулбал шударга ёсыг баримтлагч хүн хэзээд хожигдож байдаг... Юуны түрүүнд хоёр хүн бие биеийнхээ өмнө үүрэг хариуцлага хүлээж хоршин нийлж нэг ажил хийж гүйцэтгэсний эцэст шударга хүн шударга бус хүнээс илүү хожиж байсныг чи хаанаас ч олохгүй бөгөөд харин ч урвуу байдаг. Цаашилбал, төр засагтай харьцах тухайд гэвэл ямар нэгэн татвар төлөх ёстой үед ижил хэмжээний хөрөнгөтэй хирнээ шударга хүн шударга бус хүнийг бодвол илүү төлдөг. Гэтэл ямар нэгэн зүйл авах хүртэх тохиолдолд, шударга хүнд юу ч оногддоггүй, шударга бус хүн харин ч хождог.

Шударга хүмүүс төрийн ямар нэгэн албан тушаал эзэллээ ч гэсэн түүнээсээ болж хэрэв тодорхой нэг өөр хор хохирол амсдаггүй юм аа гэхэд зохих ёсны анхаарал тавьж чадахгүйгээс болж ар гэрийнх нь аж байдал доройтдог. Басхүү шударга учир олон нийтийн хэргээс өөртөө ашиг хонжоо гаргаж чаддаггүй. Хэрэв шударга ёсонд үл нийцэх хэрэг байгаад хийгээгүй тохиолдолд харин ч бүр төрөл төрөгсөд найз нөхдийнхөө зүгээс нэмэр нөөлөг болсонгүй хэмээх дургүйцэл хүлээнэ. Гэтэл шударга бус явдалт хүний тухайд гэвэл энэ бүх хэрэг бүр эсрэгээрээ гээч<sup>1</sup> гэсэн байна.

Хүмүүсийн хамтын ажиллагааны гэрээ хэлцэл, татвар төлөлт, албан тушаал зэрэгт шударга хүн үнэнчээр хандаж, бүхнийг журам дүрмийн дагуу гүйцэтгэдэг бол, шударга бус хүн ямагт заль мэх, овсгоо самбаа гарган өөртөө ашиг хонжоо гаргаж байдгийг Платон энд дурджээ. Тэрээр журам дүрмийн дагуу ажиллаад хонжоо гарна гэж хэзээ ч байхгүй гэдгийг хэлснээрээ шударга үнэнч байр суурьтай хүний сул талыг тэмдэглэсэн хэрэг юм. Ашиг хонжоо гаргана гэвэл ямагт шударга бус байх хэрэгтэй болж байна. Платон шударга бус байхыг уриалсан гэж үү? “Хүмүүс шударга бус явдлыг үйлдэх нь сайн, харин түүнийг тэвчих нь муу хэмээн хэлцдэг. Гэвч шударга бус явдлыг тэвчинэ гэдэг нь шударга бус явдлыг үйлдсэнээс ч илүү муу зүйл.

Тиймээс хүмүүс аль алиных нь амтыг мэдэрсэн цагт буюу шударга бус явдлыг өөрсдөө үйлдээд зогсоогүй мөн түүний хор хөнөөлд нэрвэгдэж байсан болохоор нэг талаас нь зугтан зайлж үл чадан, нөгөөгий нь даган мөрдөх арга хүчгүй болсоноор шударга бус явдлыг нэг талын үйлдэхгүй, нөгөө талын түүнд нэрвэгдэн хорлогдохгүйн тулд хоорондоо хэлэлцэн тохиролцоход хүрч улмаар

<sup>1</sup> Платон. Төр улс / Түүхийн философийн унших бичиг / Ш.Ганхуяг. Түүхийн философи. УБ 2006. х.154



хууль цааз тогтоосноор тэр нь хууль ёсны болон шударга ёсны хэмээх нэрийг зүүх болжээ. Шударга ёс гэдэг чухам ийм л мөн чанар, үүсэл гарвалтай юм”<sup>2</sup>.

Шударга бус үйлдлээр ашиг хонжоо олохыг бүх хүн хүснэ. Гэвч шударга бус үйлдлийнхээ төлөө шийтгэл амсдаг учраас шийтгэлээс айхдаа шударга байхаас өөр аргагүй болдог ажээ. Хэн нэгний шударга бус үйлдлийг бусад нь шүүмжлэн няцааж шийтгэл оногдуулдаг. Тэд өөрсдөө бас л тийм шударга бус үйлдэл гаргахыг хүсдэг боловч бусдын мөн адил шийтгэлээс эмээнэ. Энэ мэтчилэн хүмүүс шударга бус үйлдлийг харилцан шүүмжилж, түүнийг таслан зогсоохын тулд хууль журам боловсруулан гаргадаг гэж Платон үзжээ.

“Шударга ёсыг сахигчид нь сайн санааны үүднээс биш, харин шударга бус явдлыг үйлдэх хүч чадалгүй учраас шударга ёсыг баримталдаг бөгөөд энэ нь дараахь зүйл дээр... илүү тодорхой ойлгогдоно: Шударга ба шударга бус хоёр хүнд хоёуланд нь юу дуртайгаа хийх эрх олгоё гэж бодъё. Тэгээд дараа нь тэр хоёрын дур хүсэл чухам юунд хөтлөгдөхийг харъя. Тэгвэл бид шударга ёсыг баримтлагч хүн... шударга бус явдалтай хүний хийсэнтэй яг адил зүйл хийснийг харах болно. Харин үүний шалтгаан бол ямар ч байгалийн амьтан өөрийн ашиг тусыг бодон ач холбогдолтой зүйлд шунадагт оршдог бөгөөд үүнийг зөвхөн хууль цаазаар тодорхой хэмжээ хязгаарын хүрээнд хүчээр барьж байдаг юм”<sup>3</sup>

Шударга хүн ч, шударга бус хүн ч өөртөө хэрэгтэй гэсэн зүйлээ олж авахыг хүсдэг, түүнийхээ төлөө тэмцдэг нь ерөөсөө хүний ёс юм. Тэгвэл тэднийг чухам юугаар нь шударга, эсвэл шударга бус гэж тодорхойлж байгаа хэрэг вэ? Энэ асуудалд Платон: “хүчтэй талд тохирох зүйлийг хийж гүйцэтгэх нь шударга ёс мөн хэмээн үзэж байна”<sup>4</sup> гэж хариулсан байдаг. Хүчтэй тал гэдэг нь удирдаж байгаа тал гэсэн утгатай. Удирдлагын санаанд нийцүүлж ажиллаж, амьдарч байгаа хүнийг шударга хүн гэж нэрлэдэг гэж Платон үзсэн байна.

“Шударга ёс, шударга байх гэдэг нь угтаа хүч чадалтай тал болон удирдан залагч талын санаанд нийцдэг нэгэн ёсны бусдын ашиг шим бөгөөд харин эрх тушаалын дор үйлийг гүйцэтгэгчийн хувьд энэ нь хор гамшиг болдог байхад..., шударга бус явдал нь үүний эсрэг үнэндээ энгийн шударга хүмүүсийг удирддаг... Эзнийх нь гарт хүч чадал байдаг учраас л албат хүн эзэндээ хэрэгтэй зүйлийг нь гүйцэтгэж өгдөг. Эзэн нь гүйцэтгэсэн явдалд сэтгэл хангалуун байдаг бол албат нь хэзээ ч үгүй”<sup>5</sup>.

Платон боол эзэмшлийн нийгэмд амьдарч байсан учраас ийнхүү хэлжээ, харин өнөө үеийн нийгэмд энэ үзэл тохирохгүй гэж хэлж болно гэж үү? Хүнийг эрхшээлдээ оруулах арга нь зөвхөн боол эзэмшилд байдаггүй, өнөө үед албан тушаалын аргаар, эсвэл мөнгөөр хүнийг эрхшээлдээ оруулж байгааг бид мэднэ. Тэдний удирдлаган дор байгаа хүмүүс ажилгүй, улмаар амьдралгүй болохоос эмээхдээ хүссэн ч, хүсээгүй ч юу хий гэснийг нь гүйцэтгэж байдаг. Нэгэнт өөрсдийнх нь хүссэн зүйлийг хийж байгаа болохоор түүнийг удирдлага нь шударга хүн хэмээн тодорхойлдог байна. Ингэхлээр шударга, эсвэл шударга бус гэсэн тодорхойлолтыг зөвхөн удирдлагаасаа л авна гэсэн үг.

“Шударга ёс гэдэг нь шударга бус явдал үйлдсэн хирнээ шийтгэлгүй үлдэх бол сайн хэрэг, харин шударга бус явдлыг мэдсэн мөртлөө сөрөх хүчгүйн улмаас тэвчих бол муу хэрэг гэдгийн дунд орших зүйл бөгөөд энэ нь ач тустай зүйл болохоор хүмүүс сэтгэлээ тэжээж байгаа зүйл бус, харин хүмүүс өөрсдөө шударга бус явдлыг үйлдэх чадваргүй байдаг учраас үүнийг үнэлэн дээдэлдэг болно. Шударга бус явдал хийж чадах хэн хүний толгойд шударга бус явдал үйлдэх болон шударга бус явдалд өртөхийн эсрэг болзол хэлэлцээ хийх бодол галзуураагүй л бол яагаад ч төрөхгүй. ...Шударга ёсны... эсрэг чанар гэдэг

<sup>2</sup> Платон. Төр улс / Түүхийн философийн унших бичиг / Ш.Ганхуяг. Түүхийн философи. УБ 2006. х.154

<sup>3</sup> Платон. Төр улс / Түүхийн философийн унших бичиг / Ш.Ганхуяг. Түүхийн философи. УБ 2006. х.155

<sup>4</sup> Мөн тэнд. х.152

<sup>5</sup> Мөн тэнд. х.153



барагцаалбал, яг ийм зүйл ба миний ярьсанчлан үүний улмаас л үүссэн бөлгөө”<sup>6</sup>.

Шударга ёс буюу эзэндээ үнэнч байх чанарыг шүүмжилж, эзнийхээ эсрэг зогсч, эзэндээ шударга бус үйлдэл гүйцэтгэх нь баатарлаг гавьяатай үйлдэл болно. Эзэнд үнэнчээр зүтгэх нь тийм ч таатай биш зүйл гэдгийг ойлгосон хэрнээ эзнийхээ өмнө хүчин мөхөсдөсний улмаас тэвчээр гаргах нь түүний эсрэг тэмцэхээс арчаагүй муу чанар гэсэн утга энд илэрч байна.

Ингэхлээр Платон боол эзэмшлийг, ерөөсөө хүчирхийллийг буруушааж байсан нь харагдаж байна. Одоо манай нийгэмд ийнхүү буруушаах хүчирхийлэл дарангуйлал байгаа юу? “Ямар ч төр засаг өөрийн ашиг сонирхолд нийцүүлж хууль цаазыг тогтоодог. Ардчилсан нийгэм ардчилсан хууль цааз, дарангуй нь харгис хэрцгий гэх мэт. Хууль цаазаа тогтоосны дараагаар түүнийгээ эрхшээл дороо байгаа бүх хүмүүсийн хувьд шударга ёс хэмээн зарладаг. Чухам энэ л төр засаг баригчдад хэрэгтэй зүйл бөгөөд түүнийг зөрчсөн хүмүүсийг шударга ёс хийгээд хууль цааз завхруулагч хэмээн шийтгэл оногдуулдаг. Тиймээс л би... ямар ч төр улсад шударга ёс гэж нэг адил зүйлийг хэлдэг буюу чухамдаа оршин тогтнож буй төр засгийн хувьд ашиг тустай тийм зүйлийг хэлж байгаа юм. Тэр чинь хүч чадал шүү дээ. Тэгэхээр шударга ёс хаана ч адил зүйл хэмээн зөв ярьж байгаа хүн хүчтэй талд ашиг тустай тэр зүйлийг л хэлж байгаа хэрэг”<sup>7</sup>.

Хуулийг хүмүүс тогтооно. Тэгэхээр хууль нь цаанаа чухам ямар хүмүүсийн эрх ашгийг хамгаалж байгаа нь л гол зүйл болж байна. Хууль боловсруулсан хүмүүс өөртөө ашиг тустай зүйлийг хуулинд тусгаж, түүнийгээ хэрэгжүүлэхийг бусад хүмүүсээс шаарддаг нь нэгэнт Платоны үеэс л тодорхой байжээ. Хууль бол эрхшээлдээ байгаа хүмүүсийг хүчлэн захирах зэвсэг юм. Тэрхүү зэвсгийн үзүүрт хөтлөгдөж шударга байна гэдэг бол үнэхээр тийм сайн зүйл биш болох нь Платоны үзэл санаанаас харагдаж байна.

“Мэдээж хэрэг бид шударга ёсыг баримталлаа гээд хожим түүнийхээ төлөө бурхан тэнгэрээс ял шийтгэл хүлээхгүй ч гэлээ энэ нь өөрт ямар ч ашиггүй хийгээд шударга бус явдлаас олох ашиг орлогоо алдана гэсэн үг юм. Шударга бус явдлыг баримтлах нь бидэнд ашигтай. Харин өөрсдийн хийсэн гэм буруугаа хожим бурхан тэнгэрт хичээнгүйлэн мөргөн цагаатгаж ял шийтгэлээс зайлж болно”<sup>8</sup>. Төрийн эрх баригчдын өөрсдийнхөө ашиг сонирхолд нийцүүлэн гаргасан хуулийг мөрдөөд жирийн иргэн хүн түүнээс ашиг гаргахгүй. Иргэдэд ашиггүй, зөвхөн өөрсдөдөө л ашигтай байхаар хуулийн заалтыг томъёолсон болохоор хуулийг дагах нь иргэдэд ямар ч ашиггүй болно. “Хэрэв бид алдартай хүмүүсийн нэгэн адил шударга бус явдлыг зөв явдалтай харшуулан явбаас энэ хийгээд хойт насандаа бурхан болоод хүмүүсийн өмнө хүлээх ялгүй болно”<sup>9</sup>.

**Дүгнэлт:** Платоны үзлээр, жинхэнэ шударга ёс, эсвэл жинхэнэ шудрага бус үйл гэж байхгүй, түүнийг хүмүүс харилцан тохиролцсоны үндсэн дээр хуулиар тогтоодог. Энэ үзэл Өрнөдийн философийн түүхийн олон зуун жилийн хөгжлийг туулсаар өнөөг хүрэхдээ нийгмийн харилцаанд аль болох олонхийн эрх ашигт нийцсэн хууль боловсруулах туршлага хуримтлуулжээ. Орчин үеийн философид илүү хүндтэй байр суурийг эзэлж байгаа Попперийн үзлээр нийгмийн хууль нь олон түмний шүүмжлэлд өртөж, шинэчлэгдэж чадаж байвал хүчтэй хууль гэдгээ харуулж байгаа хэрэг болно.

<sup>6</sup> Платон. Төр улс / Түүхийн философийн унших бичиг / Ш.Ганхуяг. Түүхийн философи. УБ 2006. х.155

<sup>7</sup> Мөн тэнд. Х.151

<sup>8</sup> Платон. Төр улс / Түүхийн философийн унших бичиг / Ш.Ганхуяг. Түүхийн философи. УБ 2006. х.156

<sup>9</sup> Мөн тэнд. Х.157